



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 02 дугаар сарын 09

№ 01115 АУА-2018/32/СТА-ТЧЗ Мандалговь хот

Г

Зөрчил арилгуулах тухай

Т

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны бүтээгдэхүүн, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Дундговь аймгийн Гурван сайхан сумын Засаг даргын Тамгын газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн аudit хийх явцад дараах зөрчлүүд илэрлээ.

Үүнд:

1. Төсвийн хөрөнгөөр уралдаан тэмцээн зохион байгуулах ажлыг санхүүжүүлж, 450,500.00 /дөрвөн зуун тавин мянга таван зуун/ төгрөгийг зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын “Төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай” 147-р тогтоолын 3.6-д /улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр, ялангуяа төсвийн нэмэлт орлого, хандив болон тусламжийн орлогоор гадаад, дотоодын тойрон аялал, зугаалга, ой тэмдэглэх арга хэмжээ, урлагийн наадам, уралдаан тэмцээн зохион байгуулахгүй байх/ заасныг зөрчсөн байна.

2. "Зава Дамдин"-ы баяр наадамд зориулан Засаг даргын нөөц сангаас айраг, цагаан идээ худалдан авч, 2,370,000.00 төгрөгийг хуулиар олгогдсон бүрэн эрхэд хамааралгүй зардалд зориулалт бусаар зарцуулсан байна.




Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д /батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/, 25.10-т /Төрийн болон орон нутгийн омчид хуулийн этгээд хандив, тусламж огохийг хориглоно/, “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.3-т /Засаг дарга хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой цаг үеийн шинжлэхүүний зарим арга хэмжээг санхүүжүүлэх/, 5.1-т /Энэ журмын 2.1.1, 2.1.2 дахь заалтад зааснаас бусад зориулалтаар Засаг даргын нөөц хөрөнгөөс хөрөнгө оруулалтын зардал гаргах, олгосон хөрөнгийг зориулалт бусаар зарцуулахыг хориглоно/ заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-д /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрхэзүүн хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/ Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан

Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжсээч, аудитор, шинжсээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/ Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1.7-д /Хууль тогтоомж зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж узсэн бусад нохцол байдал/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Батлагдсан төсвийн хөрөнгийг холбогдох хууль, журмын дагуу зарцуулах, төсвийн хэмнэлтийн горимд шилжин ажиллах;
2. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг 2018 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Гурван сайхан сумын Засаг даргын Тамгын газрын дарга Б.Энхтуяа, нягтлан бодогч Д.Баярцэнгэл нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН¹: АУДИТОР  Ж.УГТАХБАЯР  4817144213 ЗЮА0039 9033475	ЗӨВШӨӨРСӨН: ДАРГА  Б.ЭНХТУЯА  НЯГТЛАН БОДОГЧ  Б.БАЯРЦЭНГЭЛ 
--	--

¹ Албан шаардлагыг биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-т Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтанд ажлаас халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хургуулна/